



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.05.21 № 1/65

Бүртгэлд тусгах тухай

Цагдаагийн ерөнхий газрын Улсын мөрдөн байцаах газрын даргын хүсэлт, түүний баталсан удирдамжийн дагуу Үндэсний аудитын газар, Сангийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Төрийн өмчийн хорооноос томилогдсон ажлын хэсэг МИАТ ХК-ийн санхүүгийн зарим үйл ажиллагаанд шалгалт хийлээ.

Шалгалтаар МИАТ ХК-ийн банкин дахь харилцах дансны жагсаалтыг нягтлан бодох бүртгэлд тусгагдсан 2013 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар гаргуулан авсан бөгөөд эдгээр харилцах дансыг харилцагч банк тус бүрээр нь холбогдох мэдээллийг тулган баталгаажуулсан болно.

Дээрх дансдыг тулган баталгаажуулах явцад Хадгаламж банкинд 3,527.17 ам.долларын үлдэгдэлтэй 10210000394 тоот харилцах данс байршиж байгаа нь тогтоогдсон бөгөөд МИАТ ХК уг дансны үлдэгдлийг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгаагүй зөрчил илэргээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ", мөн 19 дүгээр зүйлийн 19.1.4-т "эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2.1.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хадгаламж банкин дахь харилцах дансны үлдэгдэл 3,527.17 ам.долларыг нягтлан бодох бүртгэлд тусгаж, баталгаажуулах,
2. Дээрх дансны үлдэгдлийг 2013 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд тусгаж, төлбөрийн актын биелэлтийг Үндэсний аудитын газарт ирүүлэхийг МИАТ ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Жаргалсайхан, Санхүү, эдийн засгийн газрын дарга Ч.Даваасүрэн нарт хариуцуулав.

3. Төлбөрийн актын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Стратегийн удирдлагын газрын менежер Ж.Батсайхан, Нийцлийн аудитын газрын ахлах аудитор Б.Болормаа нарт даалгав.

АКТ

ТОГТООСОН:

Стратегийн удирдлагын газрын менежер



Ж.Батсайхан

Нийцлийн аудитын газрын ахлах аудитор

Б.Болормаа

ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:

МИАТ ХК-ийн гүйцэтгэх захирал



Г.Жаргалсайхан

Санхүү, эдийн засгийн газрын дарга

Ч.Даваасүрэн